

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ” ТББ-ын УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санхүүгийн тайлангийн дүгнэлт

Бид “ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ” ТББ (цаашид “ТББ” гэх) 2014 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь ТББ-ын удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид Аудитаа Олон Улсын Стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна.

Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь ТББ-ын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс ТББ-ын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Бидний хийж гүйцэтгэсэн аудит нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын 2014 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг байдлын хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ ХХК

Б.ОСОРГАРАВ

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Улаанбаатар хот, Монгол улс
2015 оны 02 дугаар сарын 10